

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөхөөс өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан хүчин төгөлдөр үйлчилж байгаа тухайн хуулиар зөвшөөрлийн харилцааг зохицуулна.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг